ТАВАН БОГД КАПИТАЛ
БОЛОМЖОО БОДИТ БОЛГО

БАНКНЫ САЛБАРЫН ТОЙМ

2022 ОНЫ 2 ДУГААР САР

2022.03.31

Банкуудын зээл олголт, багц

ТАВАН БОГД КАПИТАЛ
БОЛОМЖОО БОДИТ БОЛГО

Нийт актив
₮39.2 их наяд
Нийт зээл
₮21.1 их наяд
Хадгаламж
₮18.9 их наяд
Харилцах
₮7.3 их наяд
Өөрийн хөрөнгө
₮4.1 их наяд

Банкны салбарын ерөнхий тойм

Монгол улсад нийт 11-н арилжааны банк байдаг. Улаанбаатар хот болон орон нутагт нийт 1,391 салбар нэгж, 15,921 ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байгаагаас Улаанбаатар хотод нийт 409 салбар нэгж, гадаадад 4 салбар байршиж байна. Арилжааны банкуудаас Хаан банк, Худалдаа хөгжлийн банк, Голомт банк, Төрийн банк болон Хас банк нь системийн нөлөө бүхий банк юм.

2022 оны 3 дугаар сарын үйл явдал- Мөнгөний бодлогын мэдэгдэл

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2022 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн ээлжит бус хурлаар эдийн засаг, банк, санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал гадаад, дотоод орчны төлөв, эрсдэлийг харгалзан үзээд:

1. Бодлогын хүүг 2.5 нэгж хувиар нэмэгдүүлж 9.0 хувьд хүргэх талаар шийдвэр гаргажээ.

Банкуудын зээл олголт, зээлийн багц

» Тайлант сард банкуудын нийт зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 24.2% өсөж, 21.1 их наяд төгрөг болсон байна. Нийт зээлийн 1.5 их наяд төгрөг буюу 7.3% нь гадаад валютаар илэрхийлэгдсэн зээл, үлдсэн 92.7% нь төгрөгөөр олгогдсон зээл байна. Мөн зээлийн нийт үлдэгдлийн 46.8% нь хувийн байгууллага, 1.2% нь улсын байгууллага, 51.1% нь иргэдийн зээл, үлдсэн 0.9% нь бусад байгууллагуудад олгогдсон зээл байна.

» Тайлант сард олгогдсон ердийн зээлийн хувьд авч үзвэл төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хугацаа 32.9 сар, валют 9.2 сарын хугацаатай байна. Өмнөх тайлант сарын үзүүлэлтээс гадаад валютын хугацаа 47 хувиар буурсан үзүүлэлттэй харагдаж байгаа юм.

» Тайлант сард шинээр олгосон зээл өмнөх сараас 514.6 тэрбум төгрөгөөр буурсан бол эргэн төлөгдсөн зээл 492.9 тэрбум төгрөгөөр буурчээ. Доорх зурагт 1 дүгээр сард олгогдсон болон төлөгдсөн зээлийг өмнөх тайлант сартай харьцуулсан дэлгэрэнгүйг харуулав.

Зураг 1: 2022 оны 1-р сард олгосон, төлөгдсөн зээл (тэрбум төгрөг)



Зураг 2: 2022 оны 2-р сард олгосон, төлөгдсөн зээл (тэрбум төгрөг)



Эх сурвалж: Монголбанк

bankreformer@tavanbogdcapital.com
9405-4441, 9400-4442, 9405-4449, 9510-2229
bankreformer.tavanbogdcapital.com

Банкуудын зээл олголт, багц

ТАВАН БОГД КАПИТАЛ
БОЛОМЖОО БОДИТ БОЛГО

2022 оны 2 дугаар сарын байдлаар нийт зээлийн багц 21.1 их наяд төгрөг байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хувийн байгууллагын зээлийн багцын үлдэгдэл 1.9 их наяд төгрөг их, иргэдийн зээл 1.9 их наяд төгрөгөөр өссөн байна.

Харин зээлийн багцын хувьд 20.0%-ийг бөөний болон жижиглэн худалдаа, 8.4%-ийг уул уурхай, 7.6%-ийг боловсруулах, 7.8%-ийг барилга, 14.5%-ийг үл хөдлөх хөрөнгийн салбарт олгосон байна.

Харин тайлант сард олгогдсон зээлийн 78% буюу нийт 694.8 тэрбум төгрөгийн зээлийн багцыг иргэдийн хэрэгцээнд зориулсан бусад төрлийн зээлүүд бүрдүүлж байна. Энэ төрлийн зээлүүд нь нийт зээлийн багцын 26.7% буюу 5.6 их наяд төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Эдгээр хэрэглээний зээлийн багцыг задлавал:
» 48.9% цалингийн зээл
» 2.6% автомашины зээл
» 19% малчны зээл
» 15.4% хадгаламж барьцаалсан зээл
» 3.2% картын зээл
» 7.2% тэтгэврийн зээл

Тайлант сард нийт хэвийн зээлийн дүн 17.8 их наяд төгрөг, үүний 74.7% нь 1-5 жилийн хугацаатай, 58.5% нь урт хугацаат зээлүүд байна. Харин чанаргүй зээл өмнөх сараас 74.9 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, 2.1 их наяд төгрөг болсон байна.
Чанаргүй зээлийг бүтцээр нь задалбал:
26.2% - уул уурхай
17.9% - боловсруулах салбар
13.8% - барилга
7.6% - үл хөдлөх
8.0% - цалин тэтгэврийн зээл
6.0% - худалдаа
3.6% - хөдөө аж ахуйн зээл байна.
Мөн нийт чанаргүй зээлийн 8.5% нь гадаад валютын зээл байна.

Зураг 3: Зээлийн бүтэц, салбараар

Зураг 4: Зээлийн чанарын ангилал



Эх сурвалж: Монголбанк

Зээлийн жигнэсэн дундаж хүү

Зээлийн жигнэсэн дундаж хүү

2022 оны 2-р сарын зээлийн үлдэгдлээр тооцсон төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү өмнөх оны мөн үеэс 1.09 нэгж хувиар буурч 14.31%, валютын хүү 0.35 нэгж хувиар буурч 8.98% болсон байна.

Харин шинээр олгосон төгрөгийн зээлийн хүү буурч 14,31% бол валютын зээлийн хүү 8.98% байна. Тайлант сард бодитоор төлөгдсөн хүү 14.49% байгаа ба энэ нь өмнөх оны мөн үеэс 2.35 нэгж хувь буурсан хүү юм.

Тайлант хугацаанд шинээр олгосон зээл, шинээр татсан нийт хадгаламжийн хүүгийн зөрүү 6.84% гарсан ба өмнөх оны мөн үед уг зөрүү 5.6% байсан юм. Харин шинээр татсан хугацаатай хадгаламжийн дундаж хүүтэй харьцуулбал зөрүү 7.6% юм. 2021 онд ковид-19 эдийн засгийг дэмжих бодлогын хүрээнд хугацаагүй хадгаламжийн хүүг тэглэсэн нь хадгаламжийн хүү буурч, зөрүү ихээр өсөх нөхцөлийг бүрдүүлж байна.

Тус сар иргэдэд олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 13.9% байхад хувийн байгууллагуудад олгосон зээлийн хүү 14% байна.

Харин нийт үлдэгдлээр бол иргэдийн зээлийн хүү 12.6%, хувийн байгууллагынх 11.4% байна. Үлдэгдэлд тооцсон хүүгийн хувьд иргэдийн зээлийн хүү байгууллагын зээлийн хүүнээс илүү байгаа юм.

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2022 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн ээлжит хурлаар бодлогын хүү 9.0% хувь болсон бөгөөд банк хоорондын репо хэлцэл 6.59%, банк хоорондын хадгаламж 6.56% хүүтэй хийгдэж байна.

Зураг 5: Шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү



Зураг 6: Шинээр олгосон зээл, хадгаламжийн хүүгийн зөрүү



Зураг 7: Шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү, салбараар



Эх сурвалж: Монголбанк

Банкудын харилцах, хадгаламж, ипотекийн зээл

ТАВАН БОГД КАПИТАЛ
БОЛОМЖОО БОДИТ БОЛГО

Нийт актив
₮39.2 их наяд
Нийт зээл
₮21.1 их наяд
Хадгаламж
₮18.9 их наяд
Харилцах
₮7.3 их наяд
Өөрийн хөрөнгө
₮4.1 их наяд

Банкуудын харилцах, хадгаламж

2022 оны 2-р сарын байдлаар нийт хадгаламж өмнөх оны мөн үеэс 1.1%-аар буурч, харилцахын үлдэгдэл 28.5% хувиар өссөн байна. Үүнээс, төгрөгийн хадгаламж 0.5% өсч харин гадаад валютаар илэрхийлэгдэх хадгаламжийн хэмжээ 6.2% буурсан нь иргэд, аж ахуйн нэгжүүд гадаад валютаар хадгалах сонирхол буурсныг илэрхийлж байна. Харин төгрөгийн харилцах хамгийн өндөр хувиар буюу 41.1% өсөлт үзүүлжээ.

Тайлант хугацаанд нийт шинээр татсан төгрөгийн хадгаламжийн жигнэсэн дундаж хүү (ЖДХ) 6.69% хувь болж өмнөх сараас бууржээ. Харин гадаад валютын хадгаламжийн ЖДХ 2.59% хувь байна. Зураг 9-д шинээр татсан хугацаатай хадгаламжийн хүүг харуулав.

Ипотекийн зээл олголт

2021 оны 2-р сард нийт 661 иргэнд нийт 71.7 тэрбум төгрөгийн зээлийг шинээр олгон, МИК-д шилжүүлжээ. Сарын эцсийн байдлаар нийт 104,500 зээлдэгчийн 5.73 их наяд төгрөгийн ипотекийн зээл байна. Сарын турш нийт 71.7 тэрбум төгрөгийн шинэ зээл олгогдож, 42.6 тэрбум төгрөгийн зээлийн эргэн төлөлт хийгджээ.

Зээлийн хугацааны хувьд дээд хугацаа нь 360 сар доод хугацаа 24 сар байгаа бол тайлант сард олгогдсон зээлүүдийн дундаж хугацаа 208 сар байна.

Тухайн сард нийт зээлийн үлдэгдлийн ипотекийн зээлийн жигнэсэн дундаж хүү 7.44% хувьд хүрч, өмнөх сараас 0.09 нэгжээр буурав.

Тайланд сард нийт 160.2 тэрбум төгрөг хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн ангилалд байна. Хугацаа хэтэрсэн болон чанаргүй ангилалтай зээлийн задаргааг Зураг 11-т дэлгэрэнгүй харуулав.

*Зураг 8: *Хадгаламжийн хүү*



*Тайлбар: Шинээр татсан нийт хадгаламж болон хугацаатай хадгаламжийн хүү хоорондоо ялгаатайг анхаарна уу.

Зураг 9: Ипотекийн зээлийн эх үүсвэр /тэрбум.төг/



Зураг 10: Хугацаа хэтэрсэн болон чанаргүйд ангилагдсан ипотекийн зээлийн багц /тэрбум.төг/



Эх сурвалж: Монголбанк

Макро эдийн засгийн орчин

ТАВАН БОГД КАПИТАЛ
БОЛОМЖОО БОДИТ БОЛГО

Макро эдийн засгийн орчин

Гадаад худалдааны тэнцэл:

Экспорт, импортийн нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 39 сая ам.долларoор буурч 2,218 сая ам.долларт хүрсэн байна хүрсэн байна. Үүнд экспорт 12%-аар буюу 154 сая ам.долларoор буурч, импорт 13%-аар буюу 115 сая ам.долларoор өссөн нь нөлөөлөв. Тайлант хугацаанд худалдааны тэнцэл өнгөрсөн оны мөн үеэс 270 сая ам.долларoор буурч 143 сая ам.долларын ашигтай гарлаа.

Экспорт: 1.2 тэрбум ам.доллар (12%↓)

2022 оны эхний 2 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 12%-аар буюу 154 сая ам.долларoор буурч 1,180 сая ам.долларт хүрчээ. Экспортын бууралтад уул уурхайн болон аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний экспортын бууралт голлон нөлөөлөв. Тодруулбал, нийт экспорт 12 нэгж хувиар буурахад 7 нэгж хувийг уул уурхайн бүтээгдэхүүн, 6 нэгж хувийг аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний бууралт тус тус бүрдүүлж байна.

Импорт: 1.0 тэрбум ам.доллар (13%↑)

2022 оны эхний 2 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 13%-аар буюу 115 сая ам.долларoор өсч 1,038 сая ам.долларт хүрчээ. Импорт 13 хувиар өсөхөд хэрэглээний бүтээгдэхүүний импорт 12 нэгж хувь, нефтийн бүтээгдэхүүний импорт 8 нэгж хувиар өссөн нь голлон нөлөөлөв.

Инфляц, бодлогын хүү:

Улсын инфляц 2022 оны 2 дугаар сарын байдлаар 1.1 хувь, жилийн инфляц 14.2 хувь байна. Улаанбаатар хотын хэмжээнд 15.5% гарав. Барааны бүлгээр авч үзвэл орон сууц, ус, цахилгаан, түлш 13.54% үзүүлэлттэй, хүнсний бараа 42.9% эзэлж, үүнд мах, махан бүтээгдэхүүний үнийн өсөлт хамгийн их нөлөөлөв. Харин хүнсний бус барааны бүлэгт тээврийн хөлс, хот доторх таксины хөлс, ачаа тээврийн хэрэгслийн үйлчилгээ, хил гаалийн саатлаас үүдсэн тээвэр, ложистикийн үнэ нөлөөлж байна.

Гадаад валютын ханш, албан нөөц:

Төгрөгийн ам.доллартой харьцах ханш сарын эцсийн байдлаар 2,865.73 төгрөгт хүрсэн нь өмнөх сарын эцсээс 0.27 хувиар, өмнөх оны мөн үеэс 0.26 хувиар суларсан үзүүлэлттэй байна.

Харин төгрөгийн юаньтай харьцах сарын эцсийн ханш өмнөх сараас 1.34 хувиар, өмнөх оны мөн үеэс 3.06 хувиар суларч 454.10 төгрөгт хүрэв

Зураг 11: Төгрөг ам.долларын эрэлт (сарын хөдөлгөөнөөр)



Зураг 12: Төгрөг юанийн эрэлт (сарын хөдөлгөөнөөр)



Эх сурвалж: Монголбанк

АНДЕРРАЙТЕРИЙН ХЭЛТЭС

Банк Реформер, IPO, Бонд, Хувьцаа

ТАВАН БОГД КАПИТАЛ
БОЛОМЖОО БОДИТ БОЛГО

С.ТҮВШИНЗАЯА
Андеррайтерийн хэлтсийн дарга
9912-2583
headunderwriter@tavanbogdcapital.com

Б.АНАНД
Шинжээч
9973-7090
analyst@tavanbogdcapital.com

Б.ГАН-ЭДЭНЭЭ
Хуулийн зөвлөх
8804-5151
lawyer@tavanbogdcapital.com

95102229, 9400-4442 bankreformer@tavanbogdcapital.com bankreformer.tavanbogdcapital.com